

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024.02.15

Дархан-Уул аймаг

1967 оноос эхлэлтэй манай аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж 2023 онд БНСУ-ын Червон сум, Монтенегро улсын Бар хот, Словени улсын Айдовшина хотуудтай шинээр найрсаг харилцаа эхлүүлж, ОХУ-ын Братск хот, БНСУ-ын Кёнги аймагтай уламжлалт найрсаг харилцаагаа түлхүү хөгжүүлж, 8 улсын элчин сайд, 9 олон улсын байгууллагыг хүлээн авч, хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилсан байна.

Дархан-Уул аймаг нь 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 19 гадаад арга хэмжээ зохион байгуулж 7 санамж бичиг байгуулсан бөгөөд уг мэдээллийг тухай бүр Гадаад харилцааны яаманд тайлагнан зөвлөмж чиглэл авч ажилласан байна. Аймгийн удирдлага, төрийн албан хаагч нар гадаад улсад 4 удаагийн олон улсын форум, 4 удаагийн туршлага судлах айлчлалд нийт 26 албан хаагч хамрагдсан байна.

Гадаадын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, хөрөнгө оруулалтаар нийт 10 төсөл хөтөлбөр хэрэгжиж 11 тэрбум төгрөг, 1,307,006 евро, 20,68 сая долларын хөрөнгө татсан байна. Гадны хөрөнгө оруулалт, зээл тусламжаар хийгдсэн онцлох ажиллуудаас дурдвал:

- Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Дархан-Уул аймагт 29 841м² талбайтай, нийт 33 үндсэн нэгжтэй “Нэгдсэн эмнэлэг” шинээр барих төслийн ажлыг эхлүүлэхээр судалгааны ажил хийгдэж байна.
- Азийн Хөгжлийн банкны нийт 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цогц үйлчилгээ үзүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-тэй болсон.
- “Найрамдал” төслийн хүрээнд 2023 онд Дархан-Уул аймгийн жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор нийт 7 гарааны бизнес, мөн эмнэлгийн үйлчилгээг цахимжуулах, ТАХ-ыг цахимжуулах сургалт, дахин төлөвлөлт зэрэг нийт 5 зорилтот төсөл болон бусад төсөл хөтөлбөрүүдэд нийт 640 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Италийн Бэлфил ХХК-ны хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймгийн үйлдвэрийн бүсэд 8 га талбайд ноос, ноолуур боловсруулах үйлдвэр баригдахаар төлөвлөгдсөн.
- Австри улсын "Ти Ар Эм" компани Дархан-Уул аймгийн нийт 14 км цэвэр усны шугам, 15 мянган ширхэг ухаалаг тоолуурыг нэмэлтээр суурилуулах болсон. Уг төсөл нь Австри улсын “ЮНИ КРЕДИТ” банкны санхүүжилтээр эргэн төлөх нөхцөлгүйгээр 7,5 сая еврогийн хөрөнгө оруулалтгаар хэрэгжих юм.

1.Гадаадын хотууд болон Олон улсын байгууллагатай шинээр холбоо тогтоох чиглэлээр:

1. Дархан-Уул аймагт ноос, ноолуур боловсруулах үйлдвэр барихаар Италийн Бэлфил ХХК, Ханбогд кашмертай гурвалсан санамж бичгийг байгуулав. Ноос,

Ноолуур боловсруулах тус үйлдвэр нь Дархан-Уул аймгийн 13-р баг, үйлдвэрийн бүсэд 8 га талбайд баригдахаар төлөвлөгдсөн.



Үр дүн: Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын 45 хувийг Дархан-Уул аймагт төвлөрүүлж, шинээр 300 гаруй ажлын байр бий болгохоор зорьж байна.

2. Дархан-Уул аймгийн Оюуны-Ирээдүй цогцолбор сургууль нь сурагчдынхаа Солонгос хэл сурах идэвхийг өрнүүлэх, ярих чадварыг ахиулах зорилгоор 2022 оноос БНСУ-ын Квангжу хотын Чусон их сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, гэрээний дагуу 2023.07.20-нд анги кабинет байгуулах тохижуулах талаар судлахаар тус сургуулийн ерөнхий захирал бусад бүрэлдэхүүний баг манай аймагт айлчиллаа.



Үр дүн: Оюуны-Ирээдүй цогцолбор сургууль БНСУ-ын “Чусон” их сургуулийн нэрэмжит солонгос хэлний тэнхимтэй боллоо.

3. 2023.08.31-нд Дархан-Уул аймгийн Хонгор сум, БНСУ-ын Канвон аймгийн Чеорвон сумтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.



Үр дүн: Хөдөө аж ахуйн салбарт дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, харилцан туршлага солилцох, улирлын чанартай ажилд зуучлахыг дэмжихээр болсон.

4. 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр УИХ-ын гишүүн Г. Дамдинням, Дархан-Уул аймгийн ЗДТГ, БНСУ-ын Сөүл хотын Ихуа эмэгтэйчүүдийн их сургуулийн эмнэлэгтэй хамтран ажиллах 3 талт гэрээг байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд:




- Дархан-Уул аймагтай эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын чиглэлээр хамтран ажиллах, өвчтөн, үйлчлүүлэгчдийг оношилгоо, эмчилгээ хийлгэхээр EUMC руу илгээх зэрэг ажлуудыг хамтран хийх,

- Аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор орчин үеийн эмчилгээ, оношлогооны чиглэлээр мэдээлэл солилцох, аймгийн эмнэлгийн ажилтнуудыг сургалт сөмнөрт хамруулахад хамтран ажиллахаар тохиролцлоо.

Үр дүн: Дархан-Уул аймгийн зайлшгүй эмчилгээ шаардлагатай хүнд хэцүү өвчтөн М.Энхтөрийг нэг асран хамгаалагчийн хамт тус эмнэлэгт үнэ төлбөргүй мэс засалд орох, нөхөн сэргээх эмчилгээ хийлгэсэн.

5. Словени улсын Айдовшина хот Дархан-Уул аймаг хооронд байгаль орчин, эрчимжсэн газар тариалан, хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд ноу-хау дамжуулах эсвэл зөвлөн туслах хэлбэрээр дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтарч ажиллах “Харилцан ойлголцлын санамж бичиг” солилцлоо.



6. 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Бар хот болон Дархан-Уул аймаг хооронд тогтвортой аялал жуулчлал, зам тээвэр, төрийн байгууллага, хувийн хэвшил, их сургуулиудын хамтын ажиллагаа, соёл, амралт, спорт чиглэлээр хамтарч ажиллах “Харилцан ойлголцлын санамж бичиг” солилцлоо.



2. Шууд болон ах дүүгийн харилцаат хотуудын уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр:

1. 2023 оны 07 сарын 08-ны өдөр БНСУ-ын Кёнги аймагтай хамтын ажиллагааг өргөжүүлэн, хөгжүүлсэний 9 жилийн ойг тохиолдуулан талууд найрсаг харилцааны санамж бичгийг дахин шинэчлэн байгуулав.




Үр дүн: - Манай аймагт 2 түрэгний машин хандивлаж уг машиныг 2024.01.31-ны өдөр гааль дээр хүлээн авсан.

- Хөгжлийн бэрхшээлтэй болон аутизмтай хүүхдүүдтэй ажилдаг 10 багшийг БНСУ-д мэргэшүүлэх сургалтанд явуулахаар тогтсон.**

- Дархан-Уул аймагт Кёнги аймгийн хөрөнгө оруулалтаар “Кёнги аймгийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн” байгуулахаар тогтсон.

2. Дархан-Уул аймаг нь Оросын Холбооны Улсын Эрхүү мужийн Братск хоттой 2019 онд анх харилцаа тогтоох, хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зурж байсан. Энэ хүрээнд зуны улиралд хоёр хотын хүүхдүүдийг зусланд солилцоогоор амраах харилцан ойлголцлын гэрээ байгууллаа.



Гэрээнд Дархан-Уул аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, Братск хотын дарга Серебренников Сергей Васильевич нар гарын үсэг зурж баталгаажуулсан юм.

Найрсаг хамтын ажиллагааны уулзалтад:

ОХУ-ийн Братск хотоос: Братск хотын дарга Серебренников Сергей Васильевич, Думын дарга Павлова Лариса Михайловна, Братск хотын даргын 1 дүгээр орлогч Яковлев Александр Александрович, Эдийн засгийн хөгжлийн хорооны дарга Петухова Наталья Валерьевна, Хэвлэлийн албаны дарга Мавлюкеева Светлана Искандеровна

Үр дүн: 2024 оны зун хоёр хотуудаас харилцан 10, 10 хүүхэд солилцон амраахаар болсон.

3. Олон улсын арга хэмжээний хүрээнд:

1. Дархан-Уул аймагт уур амьсгалын тогтвортой ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтын экосистемийг бүрдүүлэхэд олон талын оролцоог хангах, мэдлэг хуваалцах, шинэ санаа мэдээлэл түгээх, харилцаа холбоо олон талт хамтын ажиллагааг бий болгох, хөрөнгө оруулалтын бодлого хөтөлбөр боловсруулах, санхүүжилтийн арга замуудыг тодорхойлох шийдвэр гаргах зорилгоор “Дархан тогтвортой ногоон санхүүжилт хөрөнгө оруулалтын форум-2023”-ыг зохион байгуулсан.



Форумд бодлогын яамдын шинжээчид, мэргэжилтнүүд, орон нутгийн бодлого тодорхойлогчид, Словани, Бельги, Хойд Макидони, Румын, Грек, Чех, Япон, Солонгос зэрэг орнуудын эксперт, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судлаач эрдэмтэд, энтрепренер зэрэг гадаад дотоодын 200 гаруй төлөөлөгч урилгаар оролцож Дархан хотын бизнес орчныг шинэлэг, тогтвортой, байгальд ээлтэй болгох томоохон шийдлүүдийг хэлэлцсэн.

Форумд Монгол Улс дахь НҮБ-ын Суурин Зохицуулагч Тапан Мишра хүрэлцэн ирж оролцон Дархан-Уул аймагт ногоон тогтвортой хөгжил, ногоон тогтвортой хот гэдэг ойлголтын хүрээнд ямар нэг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ тусалж дэмжихэд бэлэн гэдгийг онцлон тэмдэглэлээ.

Нээлттэй Дархан-тогтвортой ногоон санхүүжилт хөрөнгө оруулалтын форум-2023-ын хүрээнд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав.

Үр дүн: Солонгосын Би Плат Кей компани, ХААИС-ийн Дархан дахь салбар сургууль, Грийн ворк зөвлөх үйлчилгээний компани хамтран консорциум байгуулж, Дархан -Уул аймагтай нүүрс төрөгчийн зах зээл, тэр тусмаа хуванцар, хог хаягдал дахин боловсруулах бизнест хөрөнгө босгохоор талууд санамж бичиг байгуулав.

4. Дипломат төлөөлөгчийн газартай хамтран ажиллах хүрээнд:

1. 2023.02.13-ны өдөр Канад улсын Элчин сайд Кэтрин Ивкофыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар Дархан-Уул аймагт байгальд ээлтэй ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ХАА-н чиглэлийн техник технологийг нэвтрүүлэх, боловсон хүчнийг бэлтгэхэд хамтран ажиллах боломжийн талаар талууд харилцан санал солилцлоо.



2. 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Австралийн Элчин сайдын яамны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Дэйвид Прэстон, Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн захирал Л.Энхтүвшин нарыг хүлээн авч уулзан, уул уурхай, хөдөө аж ахуйн чиглэлээр ажиллах хүч гаргах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх болон бусад чиглэлд бүх талаар хамтран ажиллах талаар харилцан санал солилцлоо. Мөн Австралийн Засгийн Газрын Магистрын тэтгэлгийн тухай мэдээлэл, зөвлөгөө өгөх уулзалт зохион байгуулсан.



3. Бүгд найрамдах Турк Улсын Элчин сайд Зафер Атеш, Худалдааны төлөөлөгч Кадыр Жейлан нар 2023.04.14ны өдөр Дархан-Уул аймагт албан айлчлал хийж аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан, ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун болон албаны бусад хүмүүстэй уулзаж, хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцлоо.



4. Бээжин дахь АНУ-ын ЭСЯ-ны Бүс нутгийн олон нийтийн оролцоо хариуцсан мэргэжилтэн Кэтрин Марсичек, ЭСЯ-ны Америкийн соёл мэдээллийн төвүүдийн хөтөлбөр хариуцсан ажилтан Д.Болормаа нар 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдөр айлчиллаа.



5. 2023.09.20-ны өдөр Австрали улсын элчин сайд айлчилж, Засаг дарга цаашид хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, боловсролын чиглэлд богино, дунд хугацааны сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллахыг хүслээ.



6. 2023.09.30-ны өдөр “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд Япон улсын элчин сайд Х.Кобаяши Дархан-Уул аймгийн ЕБ-ын 12-р сургуульд айлчиллаа. 2022 оны 3-р сард Япон улсын ЗГ-ын “Өвсний үндэс” хөтөлбөрийн буцалтгүй тусламжаар засвар хийгдсэн Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын 12-р сургуулийн засвар үйлчилгээтэй танилцлаа.



7. 2023.10.10-ны өдөр Бүгд Найрамдах Унгар Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд, доктор Обрущански Борбала Аннаг хүлээн авч уулзсан. Айлчлалын үеэр Унгар улсын их, дээд сургуулиудад тэтгэлэгтэй суралцах хөтөлбөр, боломжуудын талаар ахлах ангийн сурагчдад мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн Унгарын нэрт яруу найрагч “Петөфи Шандорын шүлгийг хэн сайн унших вэ” уралдааныг аймгийн ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулж, амжилттай оролцсон ОИЦ сургуулийн 7-12 бүлгийн сурагчдад ЭСЯ-аас өргөмжлөл хадгалууллаа.



8. БНСВУ-ын Фу То муж хооронд харилцаа тогтоох, "Хамтын ажиллагааны санамж бичиг" байгуулах талаар санал солилцохоор Бүгд найрамдах социалист Вьетнам улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Зоан Хань Дам 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Дархан-Уул аймагт албаны айлчлал хийлээ. Манай аймгийн үндсэн нөхцөл байдал, чадавх болон давуу талыг судалсны үндсэн дээр зам тээвэр мал аж ахуй, газар тариалан боловсрол эрүүл мэнд гээд боломжтой бүхий л чиглэлд хамтран ажиллаж, хамтын ажиллагааг эхлүүлэх хүсэлтэй байгаагаа Элчин сайд илэрхийллээ. 2024 онд Монгол Улс БНСВУ-тай найрамдалт харилцаа тогтоосны 70 жилийн ой тохиох тул энэ үеэр санамж бичгийг үзэглэхээр тохиролцсон.



Үр дүн: Аймгийн хамтын ажиллагаатай хотууд нэгээр нэмэгдэж, гадаад харилцаа өргөжин тэлэхээс гадна, Азийн шинэ бар хотуудын нэг болох БНСВУ-ын хөгжлийн туршлага судлах, хөдөө аж ахуйн салбар дах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой болж байна.

5. Гадаад албан паспорт

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан "Тогтвортой хотуудын түншлэл" хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Брюссель хотноо тэргүүн туршлага солилцох арга хэмжээнд оролцох зорилгоор албан паспорт мэдүүлсэн.
2. Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр АНУ-ын Охайо мужийн Дэйтон хотод зочилж, эгч дүү хотуудын харилцаа тогтоох зорилтын хүрээнд хотын Зөвлөлийн гишүүн Матт Жосеф тэргүүтэй хотын удирдлагатай уулзахаар дипломат албан паспорт мэдүүлсэн.
3. Төрийн Захиргааны Удирдлагын хэлтсийн дарга Д.Чагнаадорж БНСУ-ын Logido-Удирдах албан тушаалтныг чадавхжуулах 7 хоногийн сургалтад 2023 оны 5 дугаар сард хамрагдах зорилгоор албан паспорт мэдүүлсэн.
4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга П.Батсүх Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлангийн 2023 оны 5 дугаар сард Австрали Улсад хийсэн айлчлалын бүрэлдхүүнд оролцон явахдаа албан паспорт мэдүүлсэн.
5. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Баасанжаргал 2023 оны 12 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд БНСУ-д зохион байгуулагдах NEAR олон улсын форумд оролцохоор албан паспорт мэдүүлсэн.

6. Гадаадын буцалтгүй тусламж, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд:

1. "Монгол Улс-Европын холбоо"-ны хамтын ажиллагааг өргөжүүлэх, Дархан бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилготой "Найрамдал" төслийг 2022-2025 он хүртэл хэрэгжүүлж байна.

Уг төслийн хүрээнд 2023 онд ОУ-ын хамтын ажиллагааны 11, дотоод хамтын ажиллагааны 28 гэрээ байгуулж хамтран ажилласан байна. 2023 онд 4.5 тэрбум төгрөгийн санхүүжилт татаж, Найрамдал төслийн хүрээнд нийт 7 аж ахуйн нэгж байгууллагад гарааны бизнесийн төсөл хэрэгжүүлэх эхний санхүүжилт 270 сая төгрөг, 4 ААН байгууллагад туршилтын төсөл хэрэгжүүлэх эхний санхүүжилт 220 сая төгрөг, Нэгдсэн эмнэлэг болон 5 өрхийн эмнэлэгт E-Clinic нэгдсэн програм хангамж киоск машинууд суурилуулахад 70 сая төгрөг, Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр боловсруулах болон сургалтын орчин сайжруулахад 80 сая төгрөгийн санхүүжилт хийж, Европ Дарханы 2 удаагийн форумыг Турк, Словени улсуудад зохион байгуулж, Дархан форумын 3 удаагийн хэлэлцүүлэг 2 компанит ажил, Ухаалаг Дархан форум түүний хүрээнд ухаалаг Дархан хотын хөгжлийн концепц боловсруулах ажил, Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд Хөрөнгө оруулалтын ОУ-ын форумууд зохион байгуулж, Соёлын сэргэлт, Малчдын форум зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Тэргүүн туршлага солилцох аялал, гадаад арга хэмжээний хүрээнд 60-аад ТАХ, бизнесийн салбарын төлөөллүүдийг Турк, Монтенегро, Хорват, Словени, Белги, БНСУ зэрэг улсуудад бизнес аялал хийх боломж олгосон байна.

Мөн ХАА, Аялал жуулчлал, бизнесийн салбарын болон төрийн албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр 9 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 300 гаруй төлөөллийг хамруулжээ. Дээрх форумуудын үр дүнд МУ-ын

Засгийн Газраас Дархан-Уул аймгийг жишиг ухаалаг аймаг болгон хөгжүүлэхээр зарлаж 2024 оны улсын төсөвт 4 тэрбум төгрөгийн санхүүжилт суугдсан байна.

TACMEE төслийн хүрээнд 265 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий Хүрээлэн буй орчин судлалын 2 лаборатори байгуулж магистрын 1 хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, бакалаврын 1 хөтөлбөр шинээр боловсруулж 11 хичээлийн электрон сан бүрдүүлж 10 лабораторийн ажлын удирдамж шинээр боловсруулсан байна. Мөн энэ төслийн хүрээнд 6 багш Финландын Оулугийн их сургуульд туршлага судлах айлчлал хийж, Финландын Оулугийн их сургууль Унгарын Сегедийн их сургуулийн 7 багш харилцан айлчлал хийжээ.



Үр дүн: 2023 онд Дархан-Уул аймгийн жижиг дунд бизнесийг дэмжих зорилгоор нийт 7 гарааны бизнес, мөн эмнэлэгийн үйлчилгээг цахимжуулах, ТАХ-ыг цахимжуулах сургалт, дахин төлөвлөлт зэрэг нийт 5 зорилтот төсөл болон бусад төсөл хөтөлбөрүүдэд нийт 640 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл Европийн Холбооноос 8,422,878,662,61 төгрөгийн санхүүжилт авч, нийт 16 төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд байна.

2. Азийн Хөгжлийн банкны нийт 3,8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Дархан сумын 12 дугаар багт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд цогц үйлчилгээ үзүүлэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-тэй боллоо. Уг төслийн барилгын ажил 2020 онд эхэлж, 2023 оны 9 сард нээлтээ хийсэн.



Үр дүн: Тус төвөөр Дархан-Уул аймгийн хөгжлийн бэрхшээлтэй 5100 иргэд үйлчлүүлээд зогсохгүй төвийн бүсийн Орхон, Сэлэнгэ, Төв аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ авах боломжтой. Мөн 25 хүнийг байнгын ажлын байртай болгосон.

3. Австри улсын "Ти Ар Эм" компани Дархан-Уул аймгийн нийт 14 км цэвэр усны шугам, 15 мянган ширхэг ухаалаг тоолуурыг нэмэлтээр суурилуулах болсон. Уг төсөл нь Австри улсын "ЮНИ КРЕДИТ" банкны санхүүжилтээр эргэн төлөх нөхцөлгүйгээр 7,5 сая еврогийн хөрөнгө оруулалтгаар хэрэгжих юм.

Шинэчлэлтийн ажил 2023 оны 8-р сарын 16-ны өдрөөс эхэлсэн бөгөөд 2 жилийн хугацаанд хийж дуусгах төлөвлөгөөтэй юм.



Үр дүн: Ухаалаг тоолуурыг суурилуулснаар ус алдалт 40 хувь багасаж, айлаас ус алдлаа гэхэд алсын зайнаас удирдаж унтраах боломжтой болох юм.

4. Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Дархан-Уул аймагт шинэ жишиг аймгийн нэгдсэн 29 841м² талбайтай, нийт 33 үндсэн нэгжтэй “Нэгдсэн эмнэлэг” шинээр барих төслийн ажлыг эхлүүлэхээр судалгааны ажил хийгдэж байна. Европын сэргээн босголт хөгжлийн банкны төлөөлөл, олон улсын зөвлөх багаас нэгдсэн эмнэлэгийн клиник загварыг Эрүүл мэндийн яам, Сангийн яамны төлөөлөл болон мэргэжлийн байгууллагаас бүрдсэн ажлын хэсэгт 10 сарын 13-ны өдөр танилцуулсан.



Үр дүн: Нэг удаадаа 250 өвчтөн хэвтэн эмчлүүлэх боломжтой томоохон клиник эмнэлэгтэй болно.

5. Дээрэт Олон улсын энэрлийн байгууллага Дархан-Уул аймагтай сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хамтран ажиллаж хүмүүнлэгийн олон тусламж дэмжлэгийн үзүүлсээр ирсэн.



Дархан сумын 5 өрхийн эрүүл мэндийн төв, Орхон, Хонгор, Шарын гол сумдын 3 өрхийн эмнэлэг, Нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нярайн шарлагын аппарат, нярайн жин хэмжих төхөөрөмж, ургийн аппарат, чихний отоскоп, нярайн шарлалт хэмжих аппарат зэрэг 5 төрлийн багц бүхий нийт 70.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүллээ.

Нэгдсэн эмнэлгийн хагалгааны өрөөнд нийт 80.6 сая төгрөгийн өртөг бүхий хагалгааны ор, гэрэл, унтуулгын аппарат зэрэг тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх гэрчилгээг олголоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч, хөгжих, эмчилгээ сувилгаагаа чанартай хийлгэх орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд Зулзагын гол хүүхдийн зусланд гал тогооны тоног төхөөрөмжийн дэмжлэг тусалцааг үзүүлж байна.



Үерт автсан иргэдэд тусламжийн багц хандивлалаа.

Үр дүн: Өрхийн эрүүл мэндийн төв болон нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг нийлүүлж, нийт 223,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

7. Дархан-Уул аймгийн гадаад харилцааны цаашдын хөгжил:

2024 онд БНСВУ-н Фу То муж, БНСУ-ын Чунчонбүг-до муж, ОХУ-ын Буриад Улсын Джидинский район, Япон Улсын Ибараки мужтай болон бусад ижил түвшний хоттой найрсаг харилцааг тогтоож, аймгийн гадаад харилцааг өргөжүүлэн тэлэх зорилготой байна.

2024 оны 5 дугаар сард Найрамдал төслөөс хэрэгжүүлдэг ДЕФ төслийн “Тэргүүн туршлага солилцох форум”, 09 дүгээр сарын 1-ний өдөр БНСУ-ын “Эрүүл мэндийн аялал жуулчлалын фестивал”-ийг тус тус Дархан-Уул аймагт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Танилцсан:

Дарга

О.Хүрэлчулуун

Хянасан:

ТЗУХ-ийн дарга

Д.Чагнаадорж

Тайлан боловсруулсан:

ТЗУХ-ийн мэргэжилтэн

Ш.Мөнхжаргал

....000....